



199

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

Г  
Т  
Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж,  
үйлчилгээ үзүүлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4 заалтыг үндэслэн, нийслэлийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх улсын эрүүл мэндийн байгууллагуудын хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан хуваарийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Нийслэлийн Эрүүл мэндийн газар (С.Туул)-т тус тус даалгасугай.
3. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хуваарийг хүчингүйд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтuya)-д даалгасугай.



200

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 10 дугаар сарын 01-ны  
өдрийн 302 дүгээр тушаалын  
хавсралт

**ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Эх барихын тусlamжийн үйлчлэх хүрээ	Эмэгтэйчүүдийн тусlamжийн үйлчлэх хүрээ
1.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг	- Хөдөө орон нутгийн жирэмслэлт төрөлттэй холбоотой тусlamж, Сонгинохайрхан дүүргийн 5-11, 24, 25, 28 дугаар хороо	- Баянгол, - Сонгинохайрхан дүүргийн, -Хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүд
2.	Клиникийн нэгдүгээр амаржих газар	- Баянгол, - Хан-Уул - Чингэлтэй - Сүхбаатар - Багахангай дүүргийн бүх хороо	- Баянзүрх, - Хан-Уул, - Чингэлтэй, - Сүхбаатар, - Багахангай дүүргийн бүх хороо
3.	Нийслэлийн II амаржих газар	Сонгинохайрхан дүүргийн 1-4,12-23, 26, 27, 29-32 дугаар хороо	-
4.	Нийслэлийн III амаржих газар	-Баянзүрх дүүргийн бүх хороо	-
5.	Багануур Эрүүл мэндийн нэгдэл	Багануур дүүргийн бүх хороо,	Багануур дүүргийн бүх хороо,
6.	Налайх Эрүүл мэндийн нэгдэл	Налайх дүүргийн бүх хороо	Налайх дүүргийн бүх хороо